

Түүх 7 : Содом ба Гоморра

Библийн эшлэл
[Эхлэл 19:29]

Бурхан талын хотыг устгахдаа Абрахамыг дурсан санаж, Лотын сууж байсан хотыг устган сүйрүүлэхдээ Лотыг сүйрлийн дундаас мэнд гаргажээ.

Эрт дээр үед Содом ба Гоморра хотод амьдардаг хүмүүс их гэм нүгэл үйлдэцгээжээ.

Тэдний гэм асар их байсан тул Бурхан Абрахамд хандан тэр хотыг галд шатаан устгах төлөвлөгөө бэлдсэнээ хэлэв.

Бурханы үгийг сонссон Абрахам тэнд амьдарч байгаа дүү Лотдоо санаа нь ихэд зовж, Бурханаас хичээнгүйлэн гуйжээ.

“Бурхан минь, хэрэв Содом болон Гоморрад зөвт арван хүн байвал тэр арван хүний төлөө тэр газар нутгийг өршөөх үү?” гэхэд, Бурхан Абрахамд ингэж хариулав. “Содом болон Гоморрад зөвт арван хүн байвал Би тэр газрыг өршөөнө”

Гэвч тэнд арван зөвт хүн байсангүй.

Бурхан тэр хотыг устгахдаа өөр аргагүй боллоо. Гэсэн ч Лотын гэр бүлийг аврахаар болов.

Тэгээд Бурхан, тэнгэр элч нараараа дамжуулан Лотод ингэж хэлэв.

“Энэ хот гэм нүглээр дүүрсэн тул Бурхан энэ хотыг устгуулахаар биднийг энэ газар уруу явуулсан.

Зугтаж байхдаа огтхон ч хойшоо эргэн харж болохгүй шүү. Тал газарт зогсолгүй уул өөд гүйгээрэй!”

Бурхан Содом хотод амьдардаг бүх хүнийг хүхэрт галаар шийтгэх гэж байсан ч Абрахамыг бодсондоо Лот болон түүний гэр бүлийг амьд үлдээх гэсэн нь энэ байжээ.


Лот Зоарт ирэхэд нар мандсан байжээ.

Эзэн Бурхан Содом болон Гоморра дээр хүхэрт галыг тэнгэрээс бороо мэт буулгажээ.

Маш том хүхэрт бороо тэнгэрээс орж хоромхон зуур тэр газрын хүн, мал амьтан, орон байрыг шатааж орхив.

Тэнгэр элч нар тэдэнд, зугтаж байхдаа хойшоо бүү эргэж хараарай гэж захисан боловч,

Лотын эхнэр амлалтаа умартан эргэн хартал, тэр даруйдаа Лотын эхнэр давсан хөшөө болчихжээ.



Бүтээлч байцгаая 1. Доорх асуултад хариулаарай.



а. Содом болон Гоморра хотыг яагаад шийтгэсэн бэ?

б. Бурхан хэнийг хайрласандаа Лотыг аварсан бэ?

в. Хотыг сүйрч байх үед хэн хойшоо эргэн харсан бэ? Мөн түүнд юу тохиолдсон бэ?

● Дараах эшлэлийг уншаад цээжлээрэй. (Эхлэл 19:29)

Бурхан талын хотыг устгахдаа Абрахамыг дурсан санаж, Лотыг сүйрлийн дундаас мэнд гаргажээ.

Аюулгүй газар руу явах боломжтой 1-7 гэсэн дугаараас нэг дугаарыг сонгоорой. Зүүнээс баруун тийшээ хөдлөх бөгөөд босоо шугамтай тулгарах үед зугтан гарах гарц уруу хүрэх хүртэл доош эсвэл дээшээгээ явах хэрэгтэй.

